

**СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ,
АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1. Улсын Их Хурлын 2017 оны 11 дугаар тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 133-т Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хамтран боловсруулж, 2017 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан.

2. 2009 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн 20 373 гэмт хэргийн 4 255 нь, 2010 онд бүртгэгдсэн 19 825 гэмт хэргийн 4610 нь, 2011 онд үйлдэгдсэн гэмт хэргийн 22.5 хувь нь архидан согтуурсаны улмаас үйлдэгдэж байсан бол 5 жилийн дараа буюу 2016 онд 27167 гэмт хэрэг бүртгэгдсэнээс¹ 5520 буюу 20.3 хувь нь согтуугаар үйлдэгдсэн байгаа нь архи, согтууруулах ундаа хэрэглээг багасгах талаар ямар нэгэн ахиц, дэвшил гараагүй төдийгүй архидан согтуурах явдал нь гэмт хэрэг үйлдэгдэх гол шалтгаан нөхцөлийн нэг хэвээр байгааг харуулж байна.

3. Өнөөдрийн байдлаар манай улсад 48 архи, согтууруулах ундааны үйлдвэр байгаа бөгөөд энэ нь 2012 онд 75 байсантай харьцуулахад үйлдвэрийн тооны хувьд 40 хувиар буурсан үзүүлэлт боловч Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан мэдээгээр нэг хүнд ногдох архи, дарсны хэмжээ 2011 онд 10.6 литр байсан бол 2015 онд 7.2 литр, шар айрагны хэмжээ 2011 онд 28.1 литр байсан бол 2015 онд 25.3 литр болж манай улс энэ үзүүлэлтээр судалгаанд хамрагдсан нийт 182 орноос 76-д жагссан байна. Дээрхи тооноос харахад үйлдвэрийн тоо буурсан хэдий ч архи, согтууруулах ундааны хэрэглээ төдийлөн буураагүй нь харагдаж байна.

4. Архидан согтуурах явдалтай тэмцэх тэмцлийг үр дүнтэй болгох зорилгоор архидан согтуурах явдлыг багасгахад ямар арга хэмжээ авах шаардлагатай талаар санал асуулга явуулахад 8% нь архидан согтуурах явдлын эсрэг төр засгийн зүгээс үр дүнтэй иж бүрэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, 6 % нь архинд донтох өвчтэй хүмүүсийн сэтгэхүйг эрүүл болгох, 12% нь ард иргэдэд архи хэрэглэх ёс, зан заншлыг ард иргэдэд хүртээмжтэй өргөнөөр сурталчлан, ухуулан ойлгуулах, 22% нь хуулийн хариуцлагыг чангатгах, 15% нь ажилгүйдэл ядуурлыг бууруулах, 15% нь архи согтууруулах ундааг худалдан борлуулах цэг салбарыг цөөлөх, архины үйлдвэрлэл экспортоор оруулж ирэх архи согтууруулах ундааны хэмжээг багасгах, 18% нь архидан согтуурах явдалтай тэмцэх хууль тогтоомжийг боловсронгуй болгох, 4% нь архигүй орчин бүрдүүлэх гэж тус тус хариулжээ.

5. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээний тайланд Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгож, зохицуулалтын утга, агуулга, нэр томъёог

¹ Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээ

тодорхой, ойлгомжтой болгох шаардлагатай гэж дүгнэсэн бөгөөд тус хууль өнөөг хүртэл 17 жил гаруй хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөхдөө нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт орж байсан хэдий ч нэг хүнд ногдох согтууруулах ундааны хэмжээ, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, согтууруулах ундааны нийгэмд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөлд мэдэгдэхүйц өөрчлөлт гарахгүй байгаагаас харахад тус хуулийн зохицуулалт нь бодит байдалтай нийцээгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй гэх үндэслэлтэй талаар дурдсан байна.

6. Цагдаагийн байгууллага, алба хаагч гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд болон эргүүл, хяналтын хэсэгчилсэн болон нэгдсэн арга хэмжээний үед удаа дараа насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдан борлуулсан, тогтоосон цагийн хязгаарлалтыг хэтрүүлж ажилласан, гэмт хэрэг, зөрчил байнга гардаг аж ахуйн нэгжүүдийн талаархи мэдээллийг тусгай зөвшөөрөл олгох, цуцлах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тогтмол хүргүүлдэг хэдий ч эдгээр асуудлууд нь тухай бүр хуулийн дагуу шийдэгддэггүй, эсхүл тусгай зөвшөөрлийг цуцалсан хэдий ч дахин өөр нэрээр тусгай зөвшөөрөл, үйл ажиллагаа явуулах эрх тухайн объектод, урьд өмнөх тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгодог зэрэг нийтлэг дутагдлууд илэрч байна.

7. Судалгаагаар сурагч-өсвөр үеийнхний 29.1 хувь нь согтууруулах ундаа хэрэглэж үзсэн, 12.9 хувь нь согттол хэрэглэж үзсэн төдийгүй тэдний эцэг, эхчүүдийн 39.8 хувь нь архи, согтууруулах ундаа хэрэглэдэг, оюутан залуучуудын 38.8 хувь нь хэтрүүлэн хэрэглэдэг, 70.6 хувь нь баар, диско клубт хэрэглэдэг, оюутнуудын сургууль, амьдарч байгаа орчноос 100 метр хүрэхгүй газар яваад архи, согтууруулах ундаа авч болдог гэжээ. Үүнээс гадна архины хэрэглээний талаарх хандлагыг тодорхойлох судалгаанаас харахад 15-24 насны хүүхэд залуучуудын 56.5 хувь нь сүүлийн 1 сарын хугацаанд архи согтууруулах ундаа хэрэглэсэн гэж хариулж, 40.0 хувь нь монголчууд архи, согтууруулах ундааг нэг дор их хэмжээгээр уудаг гэдэгтэй санал бүрэн нийлж, 52.0% нь санал нийлж байна гэжээ. Энэхүү хандлага эрэгтэй, эмэгтэй, аль ч насны хүмүүст ижил байгаа нь ерөнхийдөө ихэнх хүмүүс Монголчууд архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэдэг дадалтайг хүлээн зөвшөөрч байгаа нь илэрхий, уг асуудалд бүх нийтээрээ анхаарлаа хандуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас үүсэх эрсдэлийг бууруулах ажлыг үр дүнтэй, оновчтой зохион байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага үүссэнийг илтгэж байна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, үйлчлэх, хэрэглэх, архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

1. Хуулийн төсөлд согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сэргээх журмыг тодорхой тусгаж, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хийдлийг арилгах, тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт явуулах журмыг Засгийн газар батлах, тусгай зөвшөөрлийг тухайн тусгай зөвшөөрлийг эзэмшиж байгаа хуулийн этгээдийг өөрчлөх арга замаар бусдад шилжүүлэх явдалд хяналт тавих, түүнээс тодорхой хэмжээний татвар, хураамж авах зохицуулалтыг тусгана.

2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг улсын хэмжээнд нэгдмэл байдлаар Засгийн газар баталдаг байх, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх цэгийн тоо, нормативыг хуульчлах, нутгийн өөрөө удирдах байгууллагад энэ талаар зарим эрхийг олгох эсэх асуудлыг судалж шийдвэрлэнэ.

3. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд тодорхой бус зохицуулалттай байгаа согтууруулах ундааны үйлдвэрлэлд ашиглаж байгаа тоолуурын талаархи эрх зүйн орчныг тодорхой болгох, төрийн байгууллагын үүрэг, оролцоо, тоолуурын үзлэг, шалгалт, ашиглалтын талаархи харилцааг тодорхой болгоно.

4. Согтууруулах ундааны үйлдвэрлэлд орчин үеийн шаардлагад нийцсэн боловсронгуй, ашиглахад хялбар, найдвартай, өртөг зардал багатай, өдөр тутмын үйлдвэрлэл, борлуулалтын мэдээллийг эрх бүхий байгууллагад онлайн хэлбэрээр дамжуулах, үйлдвэрлэлт зайнаас хяналт тавих боломж бүхий нэгдсэн сүлжээ, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх эрх зүйн орчныг бий болгох талаар тодорхой зохицуулалтуудыг тусгана.

5. Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны төрөл, зэрэглэлийг тогтоож, тэдгээрийн онцлогт тохируулан үйл ажиллагаа явуулах, согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хуваарийг ялгамжтайгаар тогтооно.

6. Согтууруулах ундаагаар үйлчилдэг баар, цэнгээний газруудад нэвтэрч болох насны доод хязгаарыг тогтоох, согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгүүд, тэдгээрийн ажилчидад үйлчлүүлэгчийн бичиг баримтыг шалгах, согтууруулах ундаа хэрэглэж болох хуулиар тогтоосон насанд хүрсэн эсэхийг заавал тогтоох, түүний үндсэн дээр үйлчилдэг байх үүргийг хуульчилна.

7. Согтууруулах ундааг худалдаалах, түүгээр үйлчлэх цагийг хуульчлан тогтоох, ингэхдээ нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага хуульд заасантай уялдуулан хориглолт, хязгаарлалтыг нэмж тогтоох эрхтэй байх, нийтийг хамарсан аливаа арга хэмжээний үеэр согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдаалахыг хориглох, олон нийтийг хамарсан түр хугацааны, эсхүл нэг удаагийн шинжтэй арга хэмжээний үед согтууруулах ундаагаар үйлчлэх түр зөвшөөрөл олгож болох, түүнийг олгох журмыг тусгана.

8. Согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх цэгүүдийн нягтаршлыг бууруулах, тодорхой хүн ам, засаг захиргааны нэгжид ногдох согтууруулах ундаа худалдаалах, үйлчлэх цэгийн тоог тогтоож, согтууруулах ундааг гэрийн хаягаар, эсхүл шуудан, илгээмжээр хүргэх болон интернет сүлжээ ашиглан зарж борлуулах, согтууруулах ундааг үнэгүй тараах, дээж, загвар хэлбэрээр бусдыг дайлах, амталгаа хийлгэх зэрэг үйл ажиллагааг хориглоно.

9. Баар, цэнгээний газруудад “согтууруулах ундаагаар хариуцлагатай үйлчлэх хөтөлбөр”-ийг бий болгох, согтууруулах ундаагаар үйлчлэх аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдүүд болон тэдгээрийн ажилчдыг уг хөтөлбөрт заавал хамрагдсан байх шаардлагыг бий болгоно.

10. Гудамж талбай, парк, цэцэрлэгт хүрээлэн, олон нийтийн бусад газруудад согтууруулах ундааны зүйл хэрэглэх, нийтэд ил тод, нээлттэй барьж явах, лац, ломбо, баглаа, боодлыг нь хөндсөн байдалтай авч явахыг хориглох, хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлнэ.

11. Согтууруулах ундааны хэрэглээг бууруулах зорилгоор савлагааны хэмжээн дээр анхаарах, тухайлбал, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах зорилгоор согтууруулах ундааг 100 грамм, 50 граммаар савлах буюу жижгээр савласан согтууруулах ундаа худалдан борлуулахыг хориглоно.

12. Баар, цэнгээний газруудад шар айргийг 0,33 литрийн савалгаатайгаар худалдан борлуулдаг байх, тэдгээрийн үйлчилгээнд хэрэглэх хундага, бусад хэрэгслийн стандартыг тогтоож мөрдүүлэх зэрэг хэрэглээг багасгах зорилго бүхий бусад арга хэмжээний талаар тусгана.

13. Согтууруулах ундааны хэрэглээ, түүний хор хөнөөлийг судлах үндэсний хэмжээний мониторинг, хяналт, согтууруулах ундааны үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилтийг тогтмол шалгадаг механизмыг бий болгоно.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээ болон хэрэглээ, архидан согтууралтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хүн амыг хамгаалах, согтуурах донтой этгээдийг эмчлэх, нийгэмшүүлэх зорилго бүхий архидан согтууралттай хийх тэмцэл эрх зүйн хувьд тодорхой болж, энэхүү асуудалтай холбоотой үйл ажиллагаа явуулдаг төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хоорондын эрх, үүргийн зохицуулалт нэг мөр болно.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн байх бөгөөд уг хуулийн төсөлтэй уялдуулан Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулна.